



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Цагдаагийн газрын 2016 оны үйл ажиллагаа, үр дүн



Дотоодын хяналтыг зохих түвшинд
хэрэгжүүлсэн байна

2017 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Баян-Өлгий аймгийн аудитын газар Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган Аудитын менежер Х.Женисбек Аудитор Ж.Назгүл Б.Үүрийнтуяа 2017 оны 06 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 99668909 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр 104б тоот өрөө	Товчилсон үгийн тайлбар3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4 Бүлэг 1. Байгууллагын төсвийн төлөвлөлт, бүрдүүлэлтийн талаар <i>Цагдаагийн газрын 2016 оны төсвийн төлөвлөлт үр дүнтэй хийгдсэн байна5</i> <i>Батлагдсан төсвийн 80 хувийг ажиллагсадын цөөлин хөлс болон НДШ-ийн зардал эзэлж байна6</i> Бүлэг 2. Батлагдсан төсвийг үр ашигтай, зарцуулсан талаар. <i>Батлагдсан төсвөөс хэмнэгдсэн 30.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ7</i> <i>Тайлант онд 2 орон тоогоор дутуу ажиллаж, цалингийн санг 8.7 сая төгрөгөөр хэмнэжээ.....8</i> <i>Тээвэр шатахууны зардлаас 8.7 сая төгрөгийг хэмнэж, хэмнэсэн төсвөөр шатахун нөөц бий болгожээ10.</i> Бүлэг 3. Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтанд тавих дотоодын хяналтын талаар <i>Дотоодын хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна.....13</i> <i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллажээ.....14</i> Дүгнэлт.....17 Зөвлөмж:18 Холбогдох байгууллагын санал.....20 Саналд өгсөн тайлбар.....
--	---

Товчилсон үгийн тайлбар

ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
АДБОУС	Аудитын Дээд байгууллагын олон улсын стандарт
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
БГАҮТ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЦШСГ	Цахилгаан шугам сүлжээний газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Цагдаагийн газрын 2016 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Энэхүү аудитад Цагдаагийн газрын 2016 оны үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн баримтууд, санхүүгийн болон ажлын тайлан, бусад холбогдох баримтуудыг хамрууллаа.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан ажлын баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ. /Хавсралт №1/

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Гүйцэтгэлийн аудитын журам, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, удирдах болон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал, асуулга, лавлагаа авах, фото, судалгаа авч дүн, шинжилгээ хийх, зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын талаар товч мэдээлэл:

Цагдаагийн газарт 2016 онд 1658.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1603.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, 54.8 сая төгрөгийг өөрийн орлогоос оруулахаар төлөвлөгөө батлагджээ.

Тодотгосон төлөвлөгөөгөөр нийт 1955.9 сая төгрөгийн төсөв батлагдаж, 1901.1 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжүүлэхээр, 54.8 сая төгрөгийг өөрийн орлогоос оруулахаар төлөвлөгөөнд тусгасан байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1870.5 сая төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоос 60.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж бүгд 1931.3 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгджээ.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аудитор Ж.Назгүл ахалж, аудитор Б.Үүрийнтуяа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг хуваарийн дагуу гүйцэтгэлийн аудит хийж, тайланг бэлтгэв.

Бүлэг 1

2016 оны төсвийн төлөвлөлт үр дүнтэй хийгдсэн байна

Оршил

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар нь анх БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1940 оны 37 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймаг Ховд аймгаас тусгаарлагдан 10 сум, 71 багтайгаар Ховд голын хөвөөнд Улсын Цагдан Сэргийлэх Ерөнхий газрын даргын 1940 оны 223 дугаар тушаалаар Цагдан сэргийлэх анги болж байгуулагджээ.

2014 онд Цагдаагийн ерөнхий газрын даргын 313 дугаар тушаалаар нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсийн бүтэц, орон тоог баталж уг тушаалаар Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газар гэсэн нэршлийг Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар гэж өөрчлөн, үйл ажиллагаагаа явуулж байна.

Цагдаагийн газар нь хуулиар олгогдсон эрх үүргийнхээ дагуу аймгийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журамыг хамгаалах, хууль сахиулж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна.

2016 онд Цагдаагийн газар нь Эрүүгийн цагдаагийн тасаг, Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах тасаг, Төлөвлөлт, зохион байгуулалтын тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасаг, Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэг, Ногооннуур сум дахь Цагдаагийн тасаг, Улаанхус сум дахь Цагдаагийн хэсэг, 12 сум, 1 тосгон дахь хэсгийн төлөөлөгч, Цагааннуур тосгон дахь Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэсэг /гэрээт/ гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулжээ.


1. 2016 оны төсвийн төлөвлөлт, бүрдүүлэлтийн талаар

Батлагдсан төсвийн 80 хувийг ажиллагсадын цалин хөлс болон НДШ-ийн зардал эзэлж байна.

Цагдаагийн газрын 2016 оны үйл ажиллагаанд 1955.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1901.1 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, 39.8 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 15.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэн зарцуулахаар тусгагджээ.

Батлагдсан төсвийн бүтцийг авч үзвэл нийт төсвийн 1544.9 сая төгрөгийг буюу 80 хувийг цалин хөлс болон НДШ-ийн зардал, 90.6 сая төгрөгийг буюу 4.7 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 108.8 сая төгрөгийг буюу 5.6

хувийг хангамж бараа материалын зардал, 95.3 сая төгрөгийг буюу 4.9 хувийг эд хогшил худалдаж авах зардал, 20.5 сая төгрөгийг буюу 1.1 хувийг томилолт зочны зардал, 2.4 сая төгрөгийг буюу 0.1 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 12.1 сая төгрөгийг буюу 0.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна. Үүнийг графикаар харуулвал:



Дээрхи санхүүжүүлсэн төсвөө Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" гэсэн заалтын дагуу байгууллагын тухайн үеийн ажлын онцлог, байдалтай тохируулан төсвийн хөрөнгийн хуваарилалтыг журмын дагуу сар, улирлаар хийж, түүний дагуу санхүүжүүлж, төсвийн биелэлтэнд хяналт тавьж ажилласан байна.

Цагдаагийн газар нь 2016 онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 39.8 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 15.0 сая төгрөгийн, нийт 54.8 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөжээ.

Өөрийн орлогын бүрдүүлэлтийг авч үзвэл үндсэн үйл ажиллагааны орлогыг Монгол банкны гэрээт цагдаа нарын цалин, саатуулах байрны төлбөр, журмын хашааны төлбөр, баривчлах байрны төлбөрийн орлого, туслах үйл ажиллагааны орлогыг Үндэсний баяр наадмын үеэр замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслүүдэд тусгай зөвшөөрөл худалдсаны орлого бүрдүүлдэг байна.

Бүлэг 2

**Батлагдсан төсвөөс хэмнэгдэн 30,6 сая төгрөгийг
төсөвт төвлөрүүлжээ.**

2.1 Батлагдсан төсвийн зарцуулалтын талаар.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 1870.5 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 56.5 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 7.9 сая төгрөгийг орлого оруулсан байна. Батлагдсан төсвөөс 30.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар нь авч үзвэл ажиллагсадын цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалыг 8.7 сая төгрөгөөр, НДШимтгэлийг 1.1 сая төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 1.8 сая төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 1.0 сая төгрөгөөр, цэвэр бохир усны зардлыг 2.6 сая төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 0.1 сая төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 0.9 сая төгрөгөөр, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг 0.2 сая төгрөгөөр, урсгал засварын зардлыг 7.4 сая төгрөгөөр БГАҮТ хураамжийн зардлыг 1.0 сая төгрөгөөр, тээврийн хэрэгслийн татварын зардлыг 0.8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6.0 сая төгрөгөөр хэмнэж, байрны түрээсийн зардлыг 0.5 сая төгрөгөөр хэтэрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 56.5 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 7.9 сая төгрөгийн, нийт 64.4 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 9.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос нийт 56.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж улсын төсөвт төвлөрүүлснээс 45.9 сая төгрөгийг Монгол банкны гэрээт цагдаа нарын цалин, 2.6 сая төгрөгийг саатуулах байрны төлбөр, 5.3 сая төгрөгийг журмын хашааны төлбөр, 2.6 сая төгрөгийг баривчлах байрны төлбөрийн орлого бүрдүүлжээ.

Аймгийн ЗДТГазрын даргын 2016 оны 3-02/1352 дугаартай албан бичгээр наадмын үеэр замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслүүдэд тусгай зөвшөөрөл худалдаж, үүнээс орсон орлогыг захиран зарцуулах эрх олгожээ. Үүний дагуу тусгай зөвшөөрлийн орлогоос 7.8 сая төгрөгийн орлого оруулж, хамгаалалтанд оролцож буй албан хаагчдын хоолны зардал болон тээврийн хэрэгслийн хурд хэмжих багаж худалдаж авахад зарцуулжээ

2.2 Орон тоо, албан хаагчдын цалин олголт, тушаал шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан талаар.

Тайлант онд 2 орон тоогоор дутуу ажиллаж, цалингийн санг 8.7 сая төгрөгөөр хэмнэжээ.

Цалингийн санд нийтдээ 1520.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 1511.5 сая төгрөгийг зарцуулж 8.7 сая төгрөгийг хэмнэж, төсөвт төвлөрүүлжээ.

Тус байгууллагад 2016 онд удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 117, үйлчлэх ажилтан 4, нийт 123 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 116, үйлчлэх ажилтан 4 нийт 121 орон тоогоор ажиллажээ.

Орон тоо дутуу ажиллаж байгаа нь тэтгэвэрт гарсан, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, ажлаас халагдсан албан хаагч нарын сул байгаа орон тоонд ЦЕГазраас жилд 2 удаа сонгон шалгаруулалт явуулж, тэнцсэн хүмүүсийг 3 сарын сургалтанд хамруулдаг журамтай ба сул орон тоонд ажилтаныг шууд томилох боломжгүйгээс тухайн онд 2 орон тоогоор дутуу ажиллажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 126 дугаар тогтоолоор Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн бүтэц, орон тоог 23 орон тоогоор баталжээ. Төсөв санхүүжилтийн асуудлаас болоод 2016 оны 5-р сарын 09-ны өдрөөс Цагдаагийн газрын олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэсэг болж 16 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Үлдсэн 6 орон тоон нь Цагааннуурын Захирагчийн албаны бүтэц орон тоонд харъялагддаг байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/347 дугаар тушаалаар төв, орон нутгийн цагдаагийн зарим газар, хэлтэс, төвийн бүтэц орон тоог шинэчлэн баталсантай холбогдуулан 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн Б/138 дугаар тушаалаар Цагдаагийн газарт 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй Шүүх, шүүхчийн аюулгүй байдлыг хангах хэсэг шинээр нэмж байгуулжээ.

Цалингийн сангийн зарцуулалт, нэмэгдэл, шагнал, урамшууллыг газрын даргын тушаал, санхүүгийн баримт, материалуудыг үндэслэн шалгаж үзэхэд дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:

1. Газрын даргын 2016 оны 8 дугаар сарын 24 өдрийн А/43 дугаар тушаалаар зөрчил гаргасан 2 албан хаагчийн цалингаас бууруулах 5-10 хувийн 299.3 мянган төгрөгийн суутгалыг суутгалгүй нэмж олгож, 1 албан хаагчийн цалингаас бууруулах 5 хувийн 102.5 мянган төгрөгийн суутгалыг суутгаагүй олгосон байна.
2. Тухайн онд газрын даргын тушаалаар 3-6 сараар үндсэн цалинг 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан 6 албан хаагчид сахилгын шийтгэлтэй хугацаанд олгосон урамшууллыг бууруулсан цалингаас тооцолгүй нийтдээ 372.1 мянган төгрөгөөр илүү бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 14 зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.6-д “бүх зардал” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байгаа тул бүгд 773.9 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээс нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

2.1Тээвэр шатахуун, урсгал зардлуудыг зориулалтын дагуу зарцуулсан талаар

Тээвэр шатахууны зардлаас 8.7 сая төгрөгийг хэмнэж, хэмнэсэн төсвөөр шатахун нөөц бий болгожээ.

2016 оны тээвэр шатахууны зардалд 87.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 79.0 сая төгрөгийг зарцуулжээ. Хэмнэгдсэн 8.7 сая төгрөгийг “НИК” нефт хангамжийн салбарт шилжүүлж, урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэсэн байна.

Тайлант онд нийт 81.9 сая төгрөгийн шатахууныг орлогод авч үйл ажиллагаандаа зарцуулсан ба үүний 79.0 сая төгрөгийг төсвөөс, 2.9 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргажээ.

2016 оны эхэнд 11.2 сая төгрөгийн материалын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 93.4 сая төгрөгийн материалыг орлогод авч 104.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Цагдаагийн газарт 2016 онд урсгал засварын зардалд нийт 40.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 32.6 сая төгрөгийг зарцуулж 7.5 сая төгрөгийг хэмнэжээ. Хэмнэсэн 7.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдаж авах тухай хуулийн дагуу Өмч хамгаалах комиссын 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн хурлаар урьд нь гэрээ байгуулж бараа, ажил, үйлчилгээ нийлүүлж байсан байгууллага, аж ахуйн нэгжүүдээс гэрээгээ зөрчөөгүй байгууллагуудтай жилийн турш бараа ажил, үйлчилгээ худалдан авахаар гэрээ байгууллахаар шийдвэрлэжээ.

Уг хурлын шийлвэрийн дагуу ЦШСГазар, “Эрчим-Баян” ХХК дулааны станц, “СУАТ”ХХК цэвэр бохир ус, “НИК”ХХК ШТС, Шуудан холбоо, Монгол даатгал автомашины даатгал, “Шырах” ХХК, “Омар-Төрө” ХХК, “Нур-Ернур” ХХК-тай хуучин байгуулсан гэрээгээ сунгасан байна.

2017 оны 01-р сарын 24-ний өдрийн 34/261 тоот албан бичгийн дагуу цахилгаан хэрэгсэл, барилгын материал нийлүүлэх, 34/258 тоот албан бичгээр автомашины сэлбэг нийлүүлэх аж ахуйн нэгж байгууллагуудын хамгийн бага үнээр бараа материал нийлүүлэх санал авахаар хүсэлт хүргүүлсэн байна. Үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдээс хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Топ таймс” ХХК-тай сэлбэг нийлүүлэх, “Асыл-Али” ХХК-тай барилгын материал нийлүүлэх гэрээ байгуулж, жилийн турш гэрээний дагуу бараа материалын худалдан авалт хийсэн байна.

Бүлэг 3

Өмч хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж ажиллажээ

1. Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналт зохих журмын дагуу хийгдсэн талаар

Өмч хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж ажиллажээ.

Төсвөөс гадна Цагдаагийн ерөнхий газраас 809.1 сая төгрөгийн гудамжны камержуулалт, 18.4 сая төгрөгийн тусгай хэрэгсэл болон бусад бараа материал, 60.6 сая төгрөгийн Приус-30 автомашин, 0.4 сая төгрөгийн шийтгэврийн маягт, 77.4 сая төгрөгийн орон сууцны 2 байр, 6.7 сая төгрөгийн Тахарын албаны бараа материал болон үндсэн хөрөнгө, 0.2 сая төгрөгийн тоологоор илүүдсэн бараа материал, бүгд 972.8 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авч данс бүртгэлд тусгасан байна.

Үүнээс гадна ЦЕГазраас Цагааннуурын чөлөөт бүсийн олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэсгийн албан хаагч нарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлж ажиллахад зориулж 31.5 сая төгрөгийн 2 автомашин худалдаж авах санхүүжилтийг төсөвт суулгаж өгчээ.

Цагдаагийн газрын 2016 оны 30/1036 тоот албан бичгээр аймгийн Худалдан авах ажиллагааны албанд 2 автомашин нийлүүлэх тендер зарлуулах тухай хүсэлтийг хүргүүлсэн байна. Засаг даргын тамгын газрын даргын 2016 оны 06-р сарын 14-ний өдрийн 97 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдаж нээлттэй тендер шалгаруулжээ. 2016 оны 06-р сарын 20-ны өдөр тендер амжилтгүй болж, гүйцэтгэгч байгууллага ирээгүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дахь заалтын дагуу шууд гэрээ байгуулах эрхийг Цагдаагийн газарт олгох шийдвэр гарчээ.

Уг шийдвэрийн дагуу Цагдаагийн газар нь “Элч өртөө тээвэр” ХХК-тай шууд гэрээ байгуулж Митцубиши делика маркийн автомашиныг 21.5 сая төгрөгөөр, Тояата Приус-20 маркийн автомашиныг 10.0 сая төгрөгөөр худалдан авч, данс бүртгэлд тусгасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалтын дагуу байгууллагын даргын шийдвэрээр өмч, хөрөнгө, эд хөрөнгийн тооллого хийх комиссыг байгуулж өмч, хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, үр дүнг тооцож ажиллажээ.

Байгууллагын даргын 2016 оны 06 дугаар сарын 13-ний өдрийн А/32 тоот тушаалаар өмч, хөрөнгө, эд хөрөнгийн хагас жилийн, 12 дугаар сарын 26-ны өдрийн А/71 тоот тушаалаар жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнөх өмч, хөрөнгө, эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, тооллогын комисс нь тооллогын үр дүнгийн талаар илтгэх хуудас бичиж, хөрөнгийн тооллогын бүртгэлд гарын үсэг зурж, санхүүгийн тайланд өмч, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулж тусгасан байна.

Цагдаагийн газрын даргын 2016 оны А/32 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг болон Цагдаагийн газрын өмч хамгаалах зөвлөлөөс гаргасан саналын дагуу олон жил ашиглагдаж хугацаа нь дуссан, эвдэрч гэмтэсний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон 518.2 мянган төгрөгийн бараа материалыг аклтаж устгасан байна.

3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллажээ.

Аудитын газраас 2016 оны 11 дүгээр сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 2016 оны бүх мэдээллийг хуулийн хугацаандаа бүрэн байршуулж, зөрчил дутагдал гргаагүй байна.

Аудит хийх явцад байгууллагад шилэн дансны мэдээллийн самбар байгаа эсэх, мэдээллийг хэрхэн байршуулж байгаа байдлыг газар дээр нь шалгаж үзэхэд мэдээллийн самбарыг заасан стандартаар нь хийж, ил харагдахаар газарт байрлуулсан байна.

Гүйцэтгэлийн аудитын үр дүнгээр нийтдээ 6731.5 мянган төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 773.9 мянган төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр акт тогтоогдож, 5957.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, нийцлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Төсвийн зарцуулалтанд батлагдсан хуваарийн дагуу хяналт тавьж ажилласан байна.
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллажээ.

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ж.НАЗГҮЛ

Холбогдох байгууллагын санал